

Тайлагнах хугацаа:		2023.01.01-нээс 2023.12.31
Тайлан гаргасан: ТУЗ-ийн НБД		Д.Наранцэцэг
Хийж гүйцэтгэсэн ажлын чиг үүргүүд	1	<i>Компанийн засаглалын талаарх бодлого, дүрэм журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах</i>
		Компанийн засаглалын кодексийн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс Ногдол ашгийн бодлого болон Мэдээллийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, ТУЗ-аар батлуулснаас гадна Цалин, урамшууллын бодлого, Залгамж халааны бодлого, Эрсдэлийн удирдлагын заавар, Компанийн оролцогч талуудтай харилцах хамтран ажиллах бодлого болон комплайнсын хяналтын зааврыг мөн шинээр боловсруулан батлуулсан. Компанийн засаглалын кодексийн өөрийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Наранцэцэг Хүний нөөцийн менежер Б.Нямбаяр нар гаргаж, нийт 67 оноо буюу 93.1%-ийн үнэлгээтэйгээр холбогдох байгууллага, хүмүүст танилцуулж ажиллалаа. КЗК-ийн тайлагналын хүрээнд нэмэлтээр хийж гүйцэтгэх ажлуудыг 2023 оны ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ажлын төлөвлөгөөнд оруулан тус оны 2-р хагаст хийж гүйцэтгэх болно.
	2	<i>Компанийн сайн засаглалыг сайжруулах санал боловсруулсан байдал</i>
		2023 оны 06 сарын 16-ний өдөр болсон ТУЗ-ийн хуралд дараахи саналуудыг оруулсан. Үүнд: - компани эрсдэлээ тооцон ТУЗ-ийн дэргэд Эрсдэлийн удирдлагын хороо байгуулах эсвэл бие даасан ажилтантай байх - компани залгамж халааны бодлоготой байх Тухайн асуудлуудын ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг тайлбарлан танилцуулсанаар 11-р сард болсон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж шийдвэрлүүлээ.
	3	<i>ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, ажиллах</i>
	ТУЗ нь 2023 оны хугацаанд нийт 5 удаа хуралдсан ба үүнээс цахимаар 2 удаа, биечлэн 2 удаа, эчнээ хэлбэрээр 1 удаа хуралдаж, нийт 26 асуудалд үнэлэлт, дүгнэлт өгч, 18 шийдвэр гаргаж ажилласан. Эдгээр хурлуудын бэлтгэл зохион байгуулалт, хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулга бэлтгэх, хурлаас гарах шийдвэрийн төслийг боловсруулах, ТУЗ-ийн гишүүдэд хэлэлцэх асуудлын тухай мэдээлэл, баримт материалыг цаг тухай бүрт нь хариуцлагатайгаар хүргэх, мэдээллэх үүргээ хэрэгжүүлэн ажилласан.	
4	<i>ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах</i>	
	2023 онд Нэр дэвшүүлэх хороо 1 удаа, Цалин урамшууллын хороо 2 удаа, Аудитын хороо 3 удаа, Ёс зүйн хороо 1 удаа тус тус хуралдсан бөгөөд хурлуудын бэлтгэл ажлыг хангах, гишүүдэд зар хүргэх, хурлын материал танилцуулга бэлтгэх, хороодын хурлаас гарах дүгнэлтийн төслийг боловсруулан хороодын хурлыг амжилттай зохион байгуулан ажиллалаа. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь чиг үүргийнхээ дагуу нийт 7 дүгнэлт гаргаж ажилласан.	
5	<i>ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчид, олон нийтэд хүргэх</i>	

	<p>“Түмэн шувуут” ХК-ийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээлэл, Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний дэргэдэх хороодын бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн шийдвэр, батлагдсан дүрэм журам, шинэчлэлт, өөрчлөлт, нэмэлт мэдээллийг өөрийн www.tumenshuvuut.mn цахим хаягаар цаг тухай бүрт нь оруулж ажилласан.</p> <p>Мөн “Түмэн шувуут” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 сарын 29-ний өдөр болсон ба хурлыг “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу амжилттай зохион байгуулж, хурлын талаархи мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан мэдээллэсэн.</p> <p>Олон нийтэд мэдээлэл хүргэх байдлыг илүү дэлгэрэнгүй, цэгцтэй хүргэх үүднээс нэмэлт цэс /ТУЗ-тай холбоотой/ үүсгэн баяжуулж, сайжруулалт хийж ажилласан.</p>
6	<p><i>Компанийн дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын албатай хамтран ажиллах</i></p> <p>“Түмэн шувуут” ХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан Дотоод хяналт шалгалтын баг нь төлөвлөгөөт ажлынхаа дагуу 2023 оны 02 сарын 02-нд Тэжээлийн үйлдвэрт, 2023 оны 06 сарын 30-нд Сав баглааны үйлдвэр, Шувууны аж ахуй-2 гал тогоо, Тэжээлийн үйлдвэрийн гал тогоо, Төв оффисын гал тогоонд тус тус хяналт шалгалт хийхэд хамтран ажиллаж, илэрсэн зөрчлийг арилгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа.</p>
7	<p><i>Компанийн комплайнсын ажилтны чиг үүргийн биелэлтийг хангах, хяналтыг хэрэгжүүлэх</i></p> <p>МҮХАҮТ-ын дэргэдэх БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ТӨВ-ийн “Комплайнс, эрсдэлийн удирдлага”-ын 3 цагийн сургалтанд хамрагдаж, сургалтанд хэлж зааж өгсөн мэдлэг мэдээлэл, танилцуулгыг ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдэд тайлагнасан.</p>
8	<p><i>Охин компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг хавсран гүйцэтгэсэн байдал</i></p> <p>“Түмэн шувуут” ХК-ийн охин компани болох “Усжуулах” ХКомпани нь 2023 оны 04 сарын 29-ний өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбоотойгоор шинээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг баталсан. ХЭЭХурлыг “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу зохион байгуулж, хурлаар хэлэлцэх асуудал болон хурлаас гарах шийдвэрийн төслийг боловсруулан хэлэлцүүлж, батлуулсан.</p> <p>Мөн шинээр байгуулагдсан ТУЗ нь 2023 онд 2 удаа биечлэн хуралдсан тул хурал бүрийн хэлэлцэх асуудлыг бэлтгэх, төслийг боловсруулах, шийдвэрийг батлуулах, батлагдсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, мэдээллэх ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, бүрэлдэхүүнийг баталсантай холбоотой хороодын бүтэц бүрэлдэхүүнийг баталсан шийдвэрийг зохицуулагч байгууллагад хүргүүлж мэдэгдсэн.</p>
9	<p><i>Хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас ТУЗ-д ирүүлсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхэд оролцсон байдал</i></p> <p>Хувьцаа эзэмшигчдийн зүгээс ирэх санал гомдол, хүсэлт, өргөдөл зэргийг www.tumenshuvuut.mn цахим хаягаар хүлээн авдаг бөгөөд ирсэн тохиолдолд уг холбогдох албан тушаалтанд шуурхай мэдээллэж хариу хүргүүлж ажилладаг. Одоогоор ямар нэгэн хүсэлт, санал ирээгүй байна. Харин компанийн нийт ажилтнуудын хувьд бичгээр болон өөрсдийн өдөр тутамдаа байнга ашигладаг “timely” системээрээ дамжуулан ирүүлсэн санал бодол, өргөдөл хүсэлтэд хуулийн хугацаанд нь тодорхой хариу өгч ажиллалаа. 2023 онд нийт 11 өргөдөл, санал, хүсэлт ирсэнийг 100 хувь шийдвэрлэсэн байна.</p>
10	<p><i>Албан хэрэг хөтлөлтийн бүртгэл мэдээлэл</i></p>

	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын ТУЗ-ийн хурал зарлан хуралдуулах тухай нийт 5 албан бичиг, ТУЗ-ийн хурлаас гарсан нийт 18 шийдвэр, ХЭЭХ-ийн 2 тогтоол, ТУЗ-ийн дэргэдэх хороодын 7 дүгнэлт, 7 хурлын тэмдэглэл, ТУЗ-ийн хурлын 4 дэлгэрэнгүй тэмдэглэл, 1 эчнээ санал хураалтын тэмдэглэлийг тус бүрт нь бүртгэл үүсгэн хөтөлж тэмдэглэсэн.
<i>11</i>	<i>Сургалт, хөгжилд хамрагдан мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байдал</i>
	<ul style="list-style-type: none"> • Монголын дотоод хяналт, хөгжлийн холбооны “Эрсдэлийн удирдлага, дотоод хяналт шалгалтыг хийх арга зүй, эрсдэлийг тодорхойлж, удирдах арга зүй сэдэвт сургалтанд хамрагдан гэрчилгээ авсан. • МҮХАҮТ-ын дэргэдэх бизнесийн ёс зүйн төв-ийн “Комплайнс, эрсдэлийн удирдлага”-ын 3 цагийн сургалтанд хамрагдсан.
<i>12</i>	<i>ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлын гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгсөн байдал</i>
	<p>Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хурлын мэдээлэл, хурлаар хэлэлцэх асуудал, холбогдох танилцуулга материалыг цаг тухай бүрт нь бэлтгэн боловсруулж, хурлыг зохион байгуулахын зэрэгцээ Төлөөлөн Удирдах Зөвлөл, гүйцэтгэх удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах ажлыг зөв зохион байгуулан ажилласан.</p> <p>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хурлаас гарсан шийдвэр, дүгнэлтийг зохицуулах байгууллага болон олон нийтэд мэдээллэх, бичиг баримтын бүртгэл хөтлөх, хурлын тэмдэглэл бичих зэрэг хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зөв зохион байгуулж ажилласан гэж ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо дүгнэсэн байна.</p>